



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/77

Хужирт сум

Дуудлага худалдаа явуулах ажлын
хэсэг байгуулах тухай

Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулагдах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Мөнхбат- Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн


Дуудлага худалдааны хөтлөгч: Ц.Нямдорж-Газрын даамал
Тэмдэглэл хөтлөгч: М.Чимэдрэгзэн- Нярав

2. Ажлын хэсгийн дарга /Д.Мөнхбат/-д ДААЛГАХ нь:

а. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 208 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал”-ын дагуу тогтоож, зохих журмын дагуу Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар дуудлага худалдааг зохион байгуулах.

б. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ